

УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛД
ХИЙСЭН ШИНЖИЛГЭЭ
(мэдээллийн сайтуудын жишээн дээр)

Т.Энхтуяа*, Д.Дагиймаа**

*Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулийн докторант

**ХУИС-ийн Сэтгүүл зүй, медиатехнологийн тэнхимийн эрхлэгч, доктор (Ph.D)

Түлхүүр үгс: Уур амьсгалын өөрчлөлт, сайтуудын мэдээлэл, төрийн бодлого, хөтөлбөр

Хүлэмжийн хий ихэссэнээр дэлхийн дундаж температур нэмэгдэж уур амьсгал өөрчлөгдөж буй үзэгдлийг уур амьсгалын өөрчлөлт гэдэг. Өдөр тутмын хэрэглээгээр Уур амьсгалын өөрчлөлт (Climate Change) гэдэг нь орчин цагийн хүний үйл ажиллагаанаас үүдэн дэлхийн дулаарал болж, дэлхийн уур амьсгалын тогтолцоонд гарч буй өөрчлөлтийг хэлнэ. Уур амьсгалын өөрчлөлт нь температур болон цаг агаарын төлөв байдал дахь урт хугацааны өөрчлөлтийг хэлдэг бөгөөд эдгээр нь нарны цикл дэх өөрчлөлтөөр бий болох зэрэг байгалийн хүчин зүйлээс хамааралтай байж болно. Гэсэн хэдий ч 1800 оноос хойш хүний үйл ажиллагаа нь уур амьсгалын өөрчлөлтийг бий болгогч үндсэн хүчин зүйлийн нэг байсаар ирсэн бөгөөд нэн ялангуяа нүүрс, нефть, хий зэрэг чулуужсан түлшийг шатааснаас үүдэлтэйгээр уур амьсгалын өөрчлөлт бий болж

байна. Уур амьсгалын өөрчлөлт ирэх хэдэн арван жилийн хугацаанд эрчимжих төлөвтэй байгаа бөгөөд энэ нь хүн байгалийн харилцаа хамаарал, зүй тогтолд ихээхэн нөлөөлөхөөр байна (Хөгжиж буй орны хөгжил болон байгаль орчны талбар дах зан төлөвийн шинжлэх ухааны нөлөөллийн үйл ажиллагаа, 2022). Ялангуяа Монгол оронд уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө ихсэж, цөлжилт усны хомсдол, хур тунадасны хэмжээ өөрчлөгдөх, цаг агаарын эрс тэс үзэгдлүүдийн давтамж нэмэгдэх зэрэг үзэгдэл аль хэдийн үүсээд байгаа билээ. Сүүлийн 80 жилийн хугацаанд Монгол орны жилийн дундаж температур Цельсийн 2.25 градусаар нэмэгдсэн (БОАЖЯ, 2020). Хүн ам, тэр дундаа эмзэг бүлгийнхэн уур амьсгалын өөрчлөлтөд өртөөд зогсохгүй түүний нөлөөгөөр бий болсон гамшиг, эрсдэлд тэсвэрлэн үлдэх, хариу арга хэмжээ авах чадвар нь хязгаарлагдмал байгаагийн улмаас ихээхэн хохирол амсаж болзошгүй байна (БОАЖЯ, Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх Монголчуудын мэдлэг хандлага,

дадал болон мэдээллийн хэрэглээний судалгаа, 2023). Уур амьсгалын өөрчлөлтийн үр дагаваруудад гангачиг, усны хомсдол, гал түймэр, далайн түвшин өсөх, үер, туйлын мөс хайлах, хүчтэй шороон шуурга болон биологийн төрөл зүйл хомстох зэрэг өөрчлөлтүүд бий болдог ажээ.

Монгол Улсын хувьд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөг буруулах арга хэмжээг нэн даруй авах шаардлагатай байгааг хүлээн зөвшөөрч,

- 1993 онд НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц,
- 1999 онд Киотогийн протокол
- 2016 онд Уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээрт тус тус нэгдсэн.

Монгол Улс 2015 онд НҮБ-ын уур амьсгалын өөрчлөлтийн тухай конвенцын анхны Үндэсний хэмжээнд тодорхойлсон баримт бичгийг өргөн барьж хүлэмжийн хийн ялгарлыг 2030 он гэхэд 14%-иар бууруулах амлалт өгсөн. Дараа нь энэхүү зорилтоо ахиулан 2030 он гэхэд хүлэмжийн хийн ялгаралтыг 22.7%-иар бууруулах болгож шинэчилсэн. “Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Монгол улсын хөгжлийн таван жилийн үндсэн чиглэл (2021-2025 он)” удахгүй хэрэгжих “Салбарын хөгжлийн зорилтот хөтөлбөр” зэрэг нь уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэх төрийн өндөр түвшний бодлогын гол баримт бичиг юм. УИХ-аас 2011 онд баталсан “Уур амьсгалын өөрчлөлтийн үндэсний хөтөлбөр” баталсан боловч одоо хүчин төгөлдөр бус болсон. Монголд уур өөрчлөлтийн асуудлыг зохицуулах салбар дундын шинжтэй, олон талын үйл ажиллагааг зохицуулсан

тусгайлсан хууль, эрх зүйн орчин байдаггүй ч одоо мөрдөж буй салбарын зарим нэг хууль журмуудад тодорхой хэмжээгээр туссан. Гэсэн хэдий ч уур амьсгалын өөрчлөлт, түүнийг сааруулах, дасан зохицох арга хэмжээ нь үндэсний хэмжээний томоохон бодлогын баримт бичиг, хөгжлийн хөтөлбөрүүд, салбарын түвшинд цогц байдлаар тусган хэрэгжиж байна (БОАЖЯ, Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх монголчуудын мэдлэг хандлага, дадал болон мэдээллийн хэрэглээний судалгаа, 2023) хэмээн салбарын мэргэжилтнүүд дүгнэсэн байна.

Нийт хүн амын дунд уур амьсгалын өөрчлөлт, түүний хор нөлөөг таниулан ойлгуулах нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад хувь нэмэр оруулах, дасан зохицох арга замуудад суралцах энэ талаар хэрэгжүүлж буй төр засгийн бодлого амжилттай, үр нөлөөтэй хэрэгжихэд чухал нөлөөтэй билээ. Монголчуудын уур амьсгалын өөрчлөлтийн тухай ойлголт, өөрчлөлтийн үр нөлөөг даван туулах арга замуудын талаарх ихэнх хүмүүсийн мэдлэг дутмаг байдаг, энэ талаарх ойлголтыг нэмэгдүүлэх шаардлага тулгарч байгаа тухай БОАЖЯ-аас хийсэн дээрх судалгаанд дурьдсан байна. Тиймээс Монголын олон нийтийн мэдээллийн хэрэгслүүд, тэр дундаа хүн амын хамгийн их мэдээлэл авдаг суваг болох мэдээллийн сайтуудад уур амьсгалын өөрчлөлтийн сэдвээр нийтэлж мэдээлж байгаа байдлыг тодруулах судалгааг хийлээ. Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хэрэглэгчдээ татахын тулд дижитал платформ, тэр дундаа сошиал медиа сувгууд руу


ихээр шилжиж байна. 2023 оны судалгаагаар хүн амын 73.6 хувь зурагт, 63.7 хувь нь интернэтээр улс төр, эдийн засаг, эрүүл мэнд, боловсрол болон байгаль орчин зэрэг чухал сэдэвт хамаарах мэдээллийг үндсэн эх сурвалж болгон авдаг (Монголын Хэвлэлийн Хүрээлэн, 2020) байна. Alexa.com-ын статистик судалгаагаар Монголын топ хандалт бүхий эхний арван сайтад багтсан Ikon.mn, Gogo.mn, News.mn, Zindaa.mn, мөн Монголын Үндэсний мэдээллийн агентлагийн Montsame.mn зэрэг таван сайтад “уур амьсгалын өөрчлөлт” түлхүүр үгээр хайлт хийн илэрцээр гарсан 10 хуудас мэдээллийг дата хэрэглэгдэхүүн болгож авлаа.

Сайтын нэр	Мэдээ нийтлэлийн тоо
Zindaa.mn	14
Gogo.mn	70
News.mn	92
Ikon.mn	75
MONTSAME	137
Нийт	388

Хүснэгт №1. Сайтуудад гарсан мэдээллийн тоо.

Судалгаагаа хийсэн таван сайтаас нийт уур амьсгалын өөрчлөлтийн сэдэвтэй 388 мэдээ, мэдээллийг түүн авч шинжилж үзсэн болно. Түлхүүр үгээр хайлт хийхэд илэрцээр 10 хуудас гарч байгаа бөгөөд нэг хуудаст 10 мэдээлэл байгаад нийт 100 ширхэг мэдээ, мэдээлэл дотроос 70-92 нь судалгааны сэдэвтэй хамааралтай байлаа. “Уур амьсгал” түлхүүр үгээр хайсан тул бусад мэдээлэл нь “уур омог, уур цан” гэх мэт өөр агуулгатай мэдээлэл байсан болно. МОНЦАМЭ

агентлагийн сайтын хувьд нэг хуудсанд 20 мэдээлэл илэрсэн ба тус агентлагийн сайтын хувьд илэрцээр гарсан эхний 10 хуудас, хуудас тус бүрийн 20 мэдээлэл нийт 200 мэдээлэл дотроос авсан гэж ойлгож болно. Зиндаа сайтын хувьд энэ сэдвээр бага мэдээлж байлаа.



Гарфик №1. Сайтуудын мэдээллийн эзлэх хувь.

Энэ сэдвээр мэдээллийн сайтууд ямар нэг байдлаар мэдээлж ирсэн ба 2021 оноос хойш эрчимтэй мэдээлж эхэлсэн нь ажиглагдлаа. Шинжилгээ хийсэн сайтууд дундаас Gogo.mn сайт бага хэдий ч тогтмол мэдээлж ирсэн байна. Мөн бусад сайтуудын адил сүүлийн хоёр жил илүү ихээр бичиж мэдээлэх болжээ. Энэ нь бидний судалж буй асуудлаар төр засгаас хэрэгжүүлж буй бодлого хөтөлбөр, дэлхийн улс орнууд анхаарлаа ихээр хандуулах болж байгаатай холбон тайлбарлаж болохоор байна. Хэдийгээр 1993 оноос “НҮБ-ын уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенц”-д нэгдсэн орсон, 2015 онд Парисын хэлэлцээрийн хүрээнд Уур амьсгалыг өөрчлөлтийн тухай анхны Үндэсний хэмжээнд тодорхойлсон баримт бичгийг өргөн барьж 2020

онд хүлэмжийг хийг бууруулах амлалтаа ахиулсан ч 2020, 2021 онуудад “Алсын хараа 2050”, “Шинэ сэргэлтийн бодлого” зэрэг хөгжлийн томоохон хөтөлбөрүүд батлагдаж

хэрэгжиж эхэлсэн нь үндэсний томоохон хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд урьд өмнөхөөсөө олон мэдээ, мэдээлэл нийтлэгдэж олон нийтэд хүрч эхэлжээ гэж дүгнэж байна.

он/ сайт	Zindaa.mn	Gogo.mn	News.mn	lkon.mn	MONTSAME
2024	13	10	32	21	32
2023		13	21	17	30
2022		2	30	12	43
2021		5	9	13	21
2020		5		4	2
2019		3		6	1
2018	1	2			2
2017		3			2
2016		3		1	3
2015		2			1
2014		2			
2013		2		1	
2012		3			
2011		3			
2010		2			
2009		7			
2008		3			
Нийт	14	70	92	75	137

Хүснэгт №2. Сайтуудад мэдээлсэн он дараалал.

Он цаг хойшлох тусам, тодруулбал, 2015, 2016, 2017, 2018 зэрэг оны мэдээллээс 2022, 2023, 2024 онуудад нийтлэгдэж буй материалууд нь илүү ач холбогдол өгсөн, учир шалтгаан, үр дагаварыг нь тайлбарласан, томоохон бодлого хөтөлбөрийн үзэл санаа, хэрэгжилт үр дүнг хэлэлцсэн маягтай байлаа. Нэг үгээр хэлбэл мэдээлж байгаа байдлыг тоо хэмжээ өссөнөөс гадна агуулга цар хүрээ өргөжсөн байна. Үнэхээр ч үүнээс хойш тогтмол анхаарал хандуулж, илүү ач холбогдол өгч тасралтгүй мэдээлж, ойлгуулж байх сэдэв мөн билээ. 2024 он дуусах болоогүй байхад урд өмнөх

жилүүдээс дутахааргүй, зарим сайт нь илүү мэдээлсэн байна гэдэг бол сүүлийн жилүүдэд энэ сэдвээр байдал тасралтгүй өсөж байгааг илтгэж байгаа юм.

Иргэд олон нийт уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, бууруулахад шаардагдах мэдлэг, ур чадварыг олгоход хэвлэл мэдээллийн хэрэгслийн нөлөө тун их. Тиймээс олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээ, мэдээлэл тогтмол явуулахаас гадна энэ сэдвээр тогтмол гардаг радио хийгээд нэвтрүүлэг, сонин сайтад тасралтгүй мэдээлж байдаг булан, нүүр байх шаардлагатай юм.




График №2. Сайтуудад мэдээлсэн он дарааллын харьцуулалт.

Уур амьсгалын өөрчлөлтийн сэдвээр мэдээлж байгаа агуулгыг нарийвчлан авч үзлээ. Хэдийгээр “Уур амьсгалын өөрчлөлт” хэмээн

нарийн тодорхой сэдэв боловч мэдээлж буй өнцөг, байр суурийг авч үзвэл үндсэн дөрвөн хэсэгт хувааж болохоор байна.




График №3. Уур амьсгалыг мэдээлж буй сэдэв, агуулга.

– УАӨ-ын талаар төр засгийн барьж буй бодлого хөтөлбөрийн тухай хийгээд Монгол болон олон улсад энэ чиглэлээр хийж буй томоохон хурал чуулганы тухай мэдээлэл,

– УАӨ-ийн хүн, байгальд үзүүлж буй сөрөг нөлөө, гамшиг осол, ган, зуд, үер байгалийн гамшигийн тухай мэдээ, мэдээлэл,

– УАӨ-д дасан зохицох арга зам, дасан зохицох чадварыг бэхжүүлэх
– УАӨ-ын талаар тоо баримт, хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн танилцуулга, бусад мэдээлэл хамгийн их хувийг эзэлж байгаа гэж хэлж болохоор байна. Уур амьсгалын өөрчлөлтийн талаар төр засгийн барьж буй бодлого хөтөлбөрийн тухай хийгээд Монгол болон олон улсад энэ чиглэлээр хийж буй томоохон хурал чуулганы тухай мэдээлэлд: Уур амьсгалын ногоон сангийн Гадаад хэрэг хариуцсан захирал С.Оюунтай төр засгийн бодлого хөтөлбөрийн тухай хийсэн ярилцлага /gogo.mn/, Монголбанк Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийг УИХ-д өргөн барихдаа Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг анх удаа харгалзсан мөнгөний бодлогын тухай нийтлэл /ikon.mn/, Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх дэлхийн удирдагчдын дээд түвшний уулзалтад оролцсон тухай тойм /news.mn/, Хөвсгөл, Булган, Дорнод, Сүхбатаар аймагт хэрэгжүүлэх “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, даван туулахад орон нутгийн боломжийг нэмэх нь” төслийн нээлтийн тухай мэдээ /montsame.mn/ зэрэг мэдээллүүдийг авч үзлээ.

Уур амьсгалын өөрчлөлтийн хүн, байгальд үзүүлэж буй сөрөг нөлөө, гамшиг осол, ган, зуд, үер байгалийн гамшигийн тухай мэдээ, мэдээлэл мөн багагүй байгаа ба “уур амьсгалын өөрчлөлт нь халиа тошин, хөрсний ус нэмэгдэхэд нөлөөлж байна” хэмээн мэдээлсэн Zindaa.mn сайтын мэдээ, мөн сайтад

“Уур амьсгалын өөрчлөлт аюулын харанга дэлдэж байна” (zindaa.mn), Дэлхийн уур амьсгал дулаарсаар. Тэгээд юу гэж? (gogo.mn), Уул уурхайн инженер, судлаач Б.Мөнхбаатарын Gogo.mn сайтад бичсэн “Дэлхий дахинаа 1760-1840 онуудад өрнөсөн Аж үйлдвэрийн анхдугаар хувьсгалаас хойш уур амьсгалын өөрчлөлт хурдацтай явагдаж, ихэнх улс орон, бүс нутагт жилд дунджаар цельсийн +1 хэмээр нэмэгдсэн байна. 1950-иад оноос хойш агаарын хэм дэлхий дахинаа 10 жилд дунджаар дэлхийн хэмжээнд 0.18 хувиар дулаарч байна...” маш их баримт мэдээлэл бүхий нийтлэл, Уур амьсгалын өөрчлөлт хүн төрөлхтөнд түгшүүрийн харанга дэлдэж байгааг НҮБ-ын шинэ судалгааны тайлан харуулжээ (ikon.mn), Уур амьсгалын өөрчлөлтөөс аадар орох давтамж нэмэгдэж байна | News.MN, БНСУ-ын сэтгүүлчид Монгол орны уур амьсгалын өөрчлөлтийг сурвалжлав (montsame.mn) зэрэг мэдээллүүдийг оруулан авч үзсэн болно.

Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох арга зам, дасан зохицох чадварыг бэхжүүлэх сэдвээр Zindaa.mn сайтад мэдээлэхдээ “МУ-ын ерөнхийлөгч У.Хүрэлсүх НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 79 дүгээр чуулганд үг хэлэхдээ: уур амьсгалын өөрчлөлтөөс үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах, дасан зохицох чадварыг сайжруулах, нийгмийн суурь үйлчилгээ, тэр дундаа боловсрол, эрүүл мэндийн хүртээмжийг нэмэгдүүлж, ажил эрхлэлт, хүнсний хангамж болон аюулгүй байдлыг сайжруулах чиглэлд түлхүү анхаарал хандуулж байна” хэмээн үзэл бодлоо илэрхийлсэн тухай мэдээлжээ. Түүнчлэн

бусад сайтууд Уур амьсгалын өөрчлөлт ба залуусын оролцоо (gogo.mn), Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон тариалангийн салбарыг хөгжүүлэх шаардлагатай (gogo.mn), Ногоон эдийн засгийн хөгжлийг дэмжихээр ХААН Банк ОУСК-тай хамтран ажиллана (News.mn), Шинэ хоршоо-Чинээлэг малчин” хөтөлбөрөөр малчдын ахуйн нөхцөл сайжирна (News.mn), Дэлхийн озоны үе давхаргыг хамгаалж, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахуй (ikon.mn), Ногоон ажлын байр карьерын шинэ хэмжүүр болж байна (News.mn), Уур амьсгалын өөрчлөлтийг хэрхэн сааруулах вэ? (montsame.mn), Хүүхдүүд уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг нөлөөллийн ажил хийж байна (montsame.mn) зэргээр мэдээлжээ. Зүй нь уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, иргэд олон нийтийн дасан зохицох чадавхийг дээшлүүлэхэд ийм агуулга, хандлагатай мэдээ, мэдээлэл, нийтлэл илүү олон байвал үр нөлөө өндөртэй санагдана. Сайтуудын агуулгыг харахад хамгийн чухал байж болох энэхүү өнцөгийг бага тусгаж байна гэж үнэлж дүгнэж болохоор байна.

УАӨ-ын талаар тоо баримт, хэрэгжиж буй төсөл хөтөлбөрийн танилцуулга, бусад мэдээлэл гэсэн энэхүү агуулгад, TIME сэтгүүл оны онцлох хүнээр уур

амьсгалын төлөө тэмцэгч охиныг нэрлэлээ (gogo.mn), ХААН Банк 70 сая ам.долларын санхүүжилт татлаа (ikon.mn), 2019 онд дэлхийн байгаль орчин, хөгжлийн салбарт гарах ТАВАН чухал өөрчлөлт (ikon.mn), Хүн зоноо даахгүй, хөх тэнгист живж буй Мальдив (News.mn), Брюссельд уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхийг уриалан олон арван мянган хүн жагсжээ (montsame.mn) гэх мэт мэдээллүүд бага цөөн боловч нийтлэгдэж байна. Агуулгын хувьд ч сонин хачинг өгүүлсэн ач холбогдол багатай ч хүмүүсийн анхаарлыг уур амьсгалын өөрчлөлтрүү хандуулж чадахаар содон сонин үйл явдлыг мэдээлсэн байна. Тухайлбал, “Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэгчид Луврийн музейн “Мона Лиза” бүтээл рүү шөл цацсан тухай” мэдээлэл хэд хэдэн сайтад гарсан байлаа.

Сайтуудад уур амьсгадын өөрчлөлтийг мэдээлж байгаа бичлэгийн төрөл зүйлийг авч үзвэл 70 орчим хувь нь мэдээ байна. Сайтууд дундаас МОНЦАМЭ агентлагийн мэдээлэл бараг 90 орчим хувь нь мэдээ байгаа нь тухайн ОНМХ нь дэлхийд таван хэлээр мэдээлэл түгээдэг Монголын цорын ганц үндэсний мэдээллийн агентлаг учраас ийм дүр зураг гарч байгаа болно. Мөн бусад сайтуудын мэдээлэлд ч 50 хувиас дээшийг мэдээ эзэлж буй дүр төрх харагдаж байна.




График №4. Уур амьсгалыг мэдээлж буй төрөл, зүйл.

Уур амьсгалын өөрчлөлтийн талаар олон төрөл зүйлээр бичиж нийтлэж байгаа ба дийлэнх хувийг мэдээ эзэлж, бас багагүй хувийг сурвалжилга эзэлж байна. Энэ нь дээрх сэдвийн ангилал дээр томоохон байр суурь эзэлж буй уур амьсгалын сэдвээр болж буй томоохон хурал чуулганаас сурвилжилж байгаа нь харагдав. Ikon.mn дээр гарч буй сурталчилгаа гэсэн ангилалд манай арилжааны банкууд НҮБ-ын Уур амьсгалын ногоон сан (УАНС)-ийн Үндэсний хэрэгжүүлэгч байгууллагаар сонгогдсон тухай мэдээлэл байна. Мөн уур амьсгалын өөрчлөлтийн шалтгаан үр дагавар, сөрөг нөлөөг ойлгон таниулсан нийтлэл сурвалжилга бага боловч байсныг дурдах нь зүйтэй. Цаашид ийм ул суурьтай, томоохон нийтлэл бүтээл илүү гаргах нь олон нийтэд хүрэх үр нөлөө өндөртэй байх нь.

Мэдээллийн хэлбэрийн хувьд фото зураг, текстээр голдуу өгсөн

байх агаад цөөн хэд нь видео мэдээлэл, хүснэгт, график, гар болон зураасан зураг ашиглажээ. Эх сурвалжаа ихэнх тохиолдолд дурдаагүй байсан ба МОНЦАМЭ агентлаг олон улсын мэдээллийн хэрэгслүүдээс авсан мэдээлэлдээ эх сурвалжаа нэрлэсэн байлаа. Зарим нэг албан мэдээ Ерөнхийлөгчийн хэвлэлийн алба, Засгийн газрын хэвлэлийн алба, ОБЕГ гэсэн эх сурвалжтай байна. Сэтгүүлчдийн хувьд энэ сэдвээр тасралтгүй дагнан бичиж байгаа байдал ажиглагдсангүй.

Уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх цаг болж, хүн төрөлхтнийг амар тайван, аюулгүй амьдрах нөхцөлийг бүрдүүлэх цаг болсныг салбар бүрийн мэргэжилтнүүд, төр засаг бүрийн удирдлагууд санал нэгтгэж хэлэлцэж байна. Байгалийн гамшиг, зуд, ган, үер, цөлжилт, усны нөөцийн хомсдол зэрэг нь бүгд уур амьсгалын өөрчлөлтийн үр дагавар юм” гэдгийг иргэний нийгмийн бай-

гууллагууд санал нэгтгэйгээр хэлж байна. Авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, бодлого хөтөлбөрт ч дэлхийд төдийгүй манай улсад бага биш байна. Иймд уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг үр дагаврыг бууруулахын төлөө нийгмийн хамгийн нөлөөтэй хэвлэл мэдээллийн салбарынхан бид хувь нэмрээ оруулах нь зүйн хэрэг юм. Иргэд олон нийтэд уур амьсгал өөрчлөгдөх шалтгаан, үр дагаварт хандах хандлага, түүнтэй холбоотой сонголт, боломж юу байж болохыг ойлгоход туслах хамгийн чадамжтай хэрэгсэл бол хэвлэл мэдээлэл билээ. БОАЖЯ-аас хийсэн судалгаагаар “Монголчуудын уур амьсгалын өөрчлөлтийн талаарх ойлголт харьцангуй сайн (67,3 хувь нь уур амьсгалын өөрчлөлтийн талаар сонссон) байна (БОАЖЯ, Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх монголчуудын мэдлэг хандлага, дадал болон мэдээллийн хэрэглээнй судалгаа, 2023) хэмээсэн нь манай хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн мэдээлэл түгээж хүргэсэний үр дүн гэж харж болно. Гэхдээ илүү өргөн хүрээнд, илүү их ойлголт мэдлэг өгөх шаардлага байна гэж харж байна. Дээр дурьдсан судалгаагаар уур амьсгалын өөрчлөлтийн талаар илүү их мэдлэг эзэмших хүсэл сонирхолтой байгааг дурдсан байдаг.

Бидний судалгаагаар мэдээллийн сайтууд энэ сэдвээр 2020 оноос хойш илүү идэвхтэй бичих, анхаарч ирсэн байна гэдэг нь харагдлаа. Энэ нь дээрх цаг үеэс уур амьсгалын өөрчлөлтийг шийдвэрлэх үндэсний хэмжээний бодлого хөтөлбөрүүд гарч, олон улсын конвенцэд нэгдэн үүрэг амлалт авч ажиллаж байгаатай

холбоотой гэж үзлээ. Бичиж буй сэдвийн хувьд хурал чуулган, бодлого хөтөлбөрийн мэдээ түлхүү байна. Хэдийгээр энэ тухай мэдээллийг хэвлэлд тусгах нь зүйтэй ч илүү олон нийтэд уур амьсгалын үр нөлөөний өнөөгийн байдал, цаашид тохиолдох эрсдэлт хүчин зүйлээс өөрсдийгөө хамгаалах дадал чадвар суулгах чиглэлийн мэдээ мэдээлэл давамгайлж байвал үр нөлөө, үр ашиг өндөр болох юм гэж харж байна. Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, иргэд олон нийтийн дасан зохицох чадавхийг дээшлүүлэхэд чиглэсэн мэдээ, мэдээлэл, нийтлэл илүү олон байвал үр нөлөөтэй юм. Судалгаа хийсэн сайтуудын агуулгыг харахад хамгийн чухал байж болох энэхүү өнцөгийг бага тусгаж байна гэж үнэлж дүгнэлээ.

Төрөл зүйлийн хувьд мэдээ давамгайлж байгаа нь судалгаагаар гарлаа. Үүний нэг үндсэн шалтгаан нь судалгаа хийсэн сайтууд маань илүү мэдээ, мэдээллийн чиглэлээр төрөлжиж ажилладагтай холбоотой. Гэсэн хэдий ч асуудлыг ул суурьтай тусгасан томоохон төрөл зүйлээр бичсэн нийтлэл материал дутмаг байна, нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзлээ.

Олон судалгаа тайлангаас харахад уур амьсгалын өөрчлөлт ноцтой асуудал болохыг, үүнийг иргэд ухамсарлаж ойлгож буй нь харагдаж байна. Мөн уг асуудалд санаа зовниж уг асуудлаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр илүү их мэдээлэл авах хүсэл сонирхолтой байгаа нь бидний анхаарах ёстой асуудлыг нэг мөн юм. Иргэд олон нийт уур амьсгалын өөрчлөлтөд

дасан зохицох, бууруулахад шаардагдах мэдлэг, ур чадварыг олгоход хэвлэл мэдээллийн хэрэгслийн нөлөө тун их. Тиймээс олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдээ, мэдээлэл тогтмол нийтлэхээс гадна энэ сэдвээр тогтмол гардаг радио хийгээд нэвтрүүлэг, сонин сайтад тасралтгүй мэдээлж байдаг булан, нүүр байх шаардлагатай юм.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. (2022). Хөгжиж буй орны хөгжил болон байгаль орчны талбар дах зан төлөвийн шинжлэх ухааны нөлөөллийн үйл ажиллагаа. Улаанбаатар.
2. БОАЖЯ. (2020). Парисын хэлэлцээрийг хэрэгжүүлэх үндэсний тодорхойлсон хувь нэмрийн зорилт.
3. БОАЖЯ. (2023). Уур амьсгалын өөрчлөлтийн талаарх Монголчуудын мэдлэг хандлага, дадал болон мэдээллийн хэрэглээний судалгаа. Улаанбаатар .
4. Уур амьсгалын өөрчлөлт гэж юу юу? (2021). <https://mongolia.peopleinneed.net/mn/uur-amsgalyn-oorchlolt-gezh-iuu-ve-7972gp>.
5. Гутеррес Н.Е. (2021). https://www.unicef.org/mongolia/mn/press_release/climate-action-people-and-planet-time-now. Retrieved from Хүн ба Эх дэлхийн төлөө уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг дорвитой арга хэмжээ авах цаг нь яг одоо.
6. Монголын Хэвлэлийн Хүрээлэн (2020). Хэвлэл мэдээллийн хэрэглээний онцлог болон залуучуудын боловсролын түвшин.

Summary

The current study aimed to examine the coverage of climate change by Mongolian media, with a particular focus on news websites, the most widely accessed by the public form of media. The research encompassed an analysis of five websites, evaluating a total of 388 news articles related to the topic of climate change. The findings of the analysis indicate that while climate change has been covered to some degree across websites, there has been a marked increase in coverage since 2021. Notably, among the websites studied, Gogo.mn, despite posting a smaller volume of articles, has consistently reported on climate change and like other websites, has substantially expanded its coverage on climate change in the past two years. This heightened attention to climate change can be attributed to the policies and programs implemented by the Government of Mongolia, as well as broader global shifts in focus toward this critical issue. In terms of types of content published, approximately 70 percent were news reports. The media plays a prominent role in disseminating the necessary knowledge and fostering the skills required for the public to adapt to and mitigate the impacts of climate change. Therefore, in addition to regular news updates, it is essential to have dedicated radio programs, TV shows, and website sections that continuously feature articles and columns on climate change.

Keywords: Climate change, news website coverage, government policies and programs.